

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2008 оны 7 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 186

Улаанбаатар хот

“Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх
тусгай зөвшөөрлийн журам”-ыг шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Шинэчлэн найруулсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, банк бус санхүүгийн байгууллагын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, гэрчилгээний хавсралтын загварыг 2 дугаар хавсралтаар, банк бус санхүүгийн байгууллагын нэгжийн гэрчилгээний загварыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Хорооны 2006 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

/Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 280, 2009 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 28, 2011 оны 6 дугаар сарын 30-ны өрдийн 208, 2013 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 01, 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 532, 533 дугаар тогтоолуудаар орсон өөрчлөлтүүдийг тусгав/

Санхүүгийн зохицуулах хорооны
2008 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн
186 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**~~БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЖУРАМ~~**

**БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЗОХИЦУУЛАЛТЫН ЖУРАМ**

/Энэ журмын гарчигт Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 280 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон/

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, банк бус санхүүгийн байгууллага /цаашид ББСБ гэх/, түүний нэгж байгуулах, нэмж үйл ажиллагаа эрхлэх, ББСБ-ын хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүн, дүрмийн сангийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах, оноосон нэр өөрчлөх, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох болон бусад зохицуулалтын асуудалтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа гэж Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйл ажиллагааг ойлгоно.

1.3. Хорооноос Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авсан хуулийн этгээдийг “Банк бус санхүүгийн байгууллага /ББСБ/” гэнэ.

1.4. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Хороо нь банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохдоо тухайн ББСБ-ын дүрмийн сангийн өмчлөл, үүсгэн байгуулагдсан хэлбэрээс үл хамааран хууль, журамд заасан шаардлага, зарчмыг адил тэгш баримтална. Шаардлагатай гэж үзвэл, Хороо бодлого, зохицуулалтын хүрээнд банк бус санхүүгийн эрхлэх үйл ажиллагаа, актив пассив хөрөнгө, бусад зүйлд тусгайлан шаардлага тавьж, хязгаарлалт хийж болно.

1.5. Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ гэж Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу гадаадын иргэн, хуулийн этгээдтэй хамтарсан буюу гадаадын иргэн, хуулийн этгээдийн хөрөнгөөр Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгуулагдсан болон Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-ын хувьцааг гадаадын хөрөнгө оруулагч худалдан авсан ББСБ-ыг хэлнэ.

1.6. Улсын төсвөөс санхүүждэг хуулийн этгээд, шашны болон төрийн бус байгууллага, энэрэнгүй үйлсийн сангаас ББСБ-ын дүрмийн санд хувь хөрөнгө оруулах, хувьцааг нь худалдаж авах, үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

ХОЁР. БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1. ББСБ-ыг Компанийн тухай хуулийн 13, 18 дугаар зүйлд заасны дагуу хувь нийлүүлэх, хувьцаа гаргах, хувьцааны захиалга авах аргаар болон нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх (цаашид өөрчлөн байгуулах гэх) замаар, хувьцаат компани (цаашид ХК гэх) болон хязгаарлагдмал хариуцлагатай компани (цаашид ХХК гэх) хэлбэрээр үүсгэн байгуулж болно.

2.2. ББСБ-ыг ХК хэлбэрээр үүсгэн байгуулж буй тохиолдолд энэ журмын 2.3-д заасан баримт бичгүүдийг бүрдүүлэн ирүүлж, Хороо банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохоор шийдвэрлэсний дараа Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5-9 дүгээр зүйлийн дагуу үнэт цаасаа Хороонд бүртгүүлж, нийтэд санал болгон арилжаална.

2.3. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хуулийн этгээд нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 8, 9, 10 дугаар зүйлд нийцсэн энэхүү журмын шаардлагыг хангасан дараах баримт бичгийг Хороонд ирүүлнэ. Үүнд:

2.3.1. энэхүү журмын нэгдүгээр хавсралтын дагуу банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдөл;

2.3.2. ББСБ байгуулж, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тухай үүсгэн байгуулагчдын хурлын тэмдэглэл, шийдвэрийн эх хувь;

2.3.3. нэг этгээд үүсгэн байгуулж байгаа бол тухайн этгээдийн үүсгэн байгуулах шийдвэр;

2.3.4. нэгээс илүүүүсгэн байгуулагч байгуулах нөхцөлд үүсгэн байгуулагчид нь ББСБ-ыг үүсгэн байгуулах талаар хамтран ажиллах гэрээ байгуулах бөгөөд энэхүү гэрээнд үүсгэн байгуулагчдын хамтран ажиллах зарчим, үүсгэн байгуулагч тус бүрийн хүлээх үүрэг, тэдгээрийн худалдан авах хувьцаа болон бусад үнэт цаасны ангилал, төрөл тус бүрийн тоо, үнэ, худалдан авах хугацаа зэрэг шаардлагатай гэж үзсэн бусад асуудлыг тусгасан байх;

2.3.5. үүсгэн байгуулагчдын шийдвэрт дараах мэдээллийг заавал тусгаж холбогдох баримт бичгийг хавсаргасан байна. Үүнд:

2.3.5.1. ББСБ-ын дүрмийн санд хөрөнгө оруулах хувь нийлүүлэгчдийн жагсаалт;

2.3.5.2. зарласан болон гаргах хувьцааны тоо, төрөл, нэрлэсэн үнэ, тэдгээрээс үүсгэн байгуулагчдын худалдан авах тоо хэмжээ;

2.3.5.3. төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн бол түүний гишүүдийг сонгох, тэдгээрийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;

2.3.5.4. хянан шалгах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн бол гишүүдийг сонгох, тэдгээрийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;

2.3.5.5. ББСБ-ыг үүсгэн байгуулахтай холбогдон гарсан зардлыг нөхөн олгох тухай заалт;

2.3.5.6. үүсгэн байгуулагчдын хурлаар хэлэлцэн баталсан банк бус санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журам, заавар болон бусад зохицуулалтын баримт бичгүүдийн эх хувь эсвэл нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

2.3.6. үүсгэн байгуулагч, хуулийн этгээдийн Үндэсний татварын ерөнхий газрын Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

2.3.7. ББСБ-ын дүрэмд дараах зүйлийг тусгана:

2.3.7.1. ББСБ-ын бүрэн болон товчилсон оноосон нэр, түүний хэлбэрийг тодорхойлсон товчилсон ялгах тэмдэглэгээ;

2.3.7.2. ББСБ-ын оршин байгаа газрын хаяг;

2.3.7.3. ББСБ-ын удирдлага, зохион байгуулалтын бүтэц;

2.3.7.4. ББСБ-ын зарласан энгийн хувьцааны тоо болон дүрмийн сангийн хэмжээ;

2.3.7.5. дүрмээр давуу эрхийн хувьцааг зарласан нөхцөлд давуу эрхийн хувьцааны зарласан тоо, түүний эзэмшигчийн эрх;

2.3.7.6. хэрэв төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо;

2.3.7.7. хувь нийлүүлэгчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, хянан шалгах зөвлөл, дотоод хяналтын нэгжийн бүрэн эрх, үүрэг, хариуцлага;

2.3.7.8. ББСБ-ын үйл ажиллагааны чиглэл;

2.3.7.9. хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүн болон дүрмийн сангийн бүтцэд өөрчлөлт оруулах нөхцөл;

2.3.7.10. ББСБ их хэмжээний болон ашиг сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхэд баримтлах бодлого, энэ талаарх удирдлагын эрх, үүрэг;

2.3.7.11. хувьцааг арилжих, бусдад шилжүүлэх, харилцан хязгаарлалт хийх үйл ажиллагааг зохицуулах хууль зүйн үндэслэл, хууль тогтоомжид заасан бусад асуудал;

2.3.7.12. ББСБ нь Компанийн тухай хуулийн дагуу өөрчлөн байгуулахад Хорооноос зөвшөөрөл авах ба ийнхүү зөвшөөрөл хүсэхийн өмнө авбал зохих арга хэмжээний тухай;

2.3.7.13. ББСБ татан буугдах үндэслэл, ББСБ-ын удирдлагын буруутай үйл ажиллагаанаас иргэд, харилцагчдад учруулсан хохирлыг барагдуулах арга хэлбэр, хариуцлага, хүлээх зарчим;

2.3.7.14. дүрэмд тусгахаар холбогдох хуульд заасан бусад зүйл.

2.3.8. ББСБ-ын үүсгэн байгуулагчдын дүрмийн санд оруулсан мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны орлогоос бүрдсэн болохыг нотлох баримт бичиг, гарал үүслийн талаарх тодорхойлолтууд;

2.3.9. ББСБ-ын дүрмийн санг бүрдүүлэх мөнгөн хөрөнгийг банкинд байршуулсан эсэхийг тодорхойлсон банкны тодорхойлолт, дансны хуулга, бусад баталгаа;

2.3.10. ББСБ-ын хууль тогтоомжид заасан дүрмийн сангийн доод хэмжээг тусгасан эхлэлтийн баланс;

2.3.11. энэхүү журмын хоёр, гуравдугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт болон түүнийг нотлох баримт бичгийн хуулбар, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13.5, 13.6-д заасан шаардлагыг хангасан ББСБ-ын үүсгэн байгуулагч /үүсгэн байгуулагчид/, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлага, ажиллах боловсон хүчний талаар холбогдох байгууллагаас гаргасан дараах тодорхойлолтууд. Үүнд:

а/ татварын байгууллагад өр төлбөртэй эсэх талаарх эдгээр байгууллагын удирдлагын гарын үсэг бүхий тодорхойлолт;

б/ ял шийтгэлтэй эсэх талаарх Цагдаагийн ерөнхий газрын тухайн асуудал хариуцсан хэлтэс, тасгийн удирдлагын гарын үсэг бүхий тодорхойлолт.

в/ иргэний үнэмлэх, мэргэжлийн дипломын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар.

2.3.12. гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын хувьд тухайн орны онцлогоос шалтгаалан энэ журмын 2.3.11а, 2.3.11б-д заасан тодорхойлолтуудыг гаргаж ирүүлэх боломжгүй бол гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын үүсгэн байгуулагч /үүсгэн байгуулагчид/ нь энэ тухай баталгаа гаргаж ирүүлнэ.

2.3.13. энэхүү журмын дөрөвдүгээр хавсралтын дагуу гаргасан техник тоног төхөөрөмж, программ хангамж, ажлын байрны тодорхойлолт, түүнд техник тоног төхөөрөмж, программ хангамж, ажлын байрны найдвартай, аюулгүй ажиллагаа, нууцлал, харуул, хамгаалалтын асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар тусгаж, дурдсан шаардлагын талаар бусад этгээдтэй байгуулсан гэрээ эсхүл нотариатын байгууллагаар гэрчлүүлсэн гэрээний хуулбар;

2.3.14. энэхүү журмын тавдугаар хавсралтад заасан зөвлөмжийн дагуу боловсруулсан бизнес төлөвлөгөө;

2.3.15. шаардлагатай гэж үзсэн тохиолдолд мөнгө угаах, алан хядах ажиллагааг санхүүжүүлэхийн эсрэг арга хэмжээний тухай хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл, тодорхойлолт.

2.4. Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-д дараах нэмэлт шаардлагыг тавина.
Үүнд:

2.4.1. Ажиллах боловсон хүчний 70-аас доошгүй хувийг Монгол улсын иргэдээс бүрдүүлэх;

2.4.2. Гүйцэтгэх удирдлага нь гадаадын иргэн байгаа нөхцөлд байнгын мэргэжлийн орчуулагчтай байх;

2.4.3. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар энэ журмын 2.3-д заасан баримт бичгийг Монгол хэл дээр 2 хувь үйлдэж, орчуулсан хувийг нотариатаар гэрчлүүлсэн байх;

2.4.4. Хороо шаардлагатай гэж үзвэл тухайн орны холбогдох байгууллагуудаас холбогдох лавлагаа авна.

2.5. ББСБ нь банк бус санхүүгийн үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш хугацаанд энэхүү журмын 2.3, 2.4-д дурдсан нөхцөл, шаардлага, баримт бичигт өөрчлөлт орох тухай бүрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг ажлын 10 хоногийн дотор Хороонд ирүүлнэ.

2.6. Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх банк бус санхүүгийн байгууллагад дараах нэмэлт шаардлагыг тавина:

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 28 дугаар тогтоолоор нэмсэн/

2.6.1. Ажилтны аюулгүй байдлыг хангасан торон /шилэн/ хаалттай байх;

2.6.2. Бичсэн бичлэгийг 1 сараас доошгүй хугацаагаар архивлан хадгалдаг хяналтын камертай байх;

2.6.3. Кассын машинтай байх;

2.6.4. Тухайн төрлийн валютыг шалгагч болон мөнгө тоологч машинтай байх;

2.6.5. Гадаад валютыг худалдан авах, худалдах ханшийг нийтэд ил тод мэдээлэх самбартай байх;

2.6.6. Гадаад валютыг худалдан авах, худалдах тухай бүр гадаад валютыг худалдаж авсан, худалдсан тухай баримтыг хоёр хувь үйлдэж, нэг хувийг харилцагчид өгч, нөгөө хувийг санхүүгийн баримт болгон хадгалах;

~~2.6.7. Долоо хоног тутмын гадаад валютын арилжааны тухай мэдээг энэхүү журмын 6 дугаар хавсралтын дагуу гаргаж дараа долоо хоногийн эхний хагаст Монголбанкинд, сар тутмын валют арилжааны тухай мэдээг энэхүү журмын 7 дугаар хавсралтын дагуу гаргаж, дараа сарын 10-ны дотор Хороонд ирүүлж байх.~~

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 532 дугаар тогтоолоор хассан./

ГУРАВ. БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУХАЙ ИРҮҮЛСЭН БАРИМТ БИЧГИЙГ ХЯНАХ

3.1. Хороо холбогдох хууль тогтоомж, энэхүү журмыг үндэслэн үүсгэн байгуулагч /үүсгэн байгуулагчид/-аас ББСБ байгуулж, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн баримт бичгийг дараах байдлаар хянана. Үүнд:

3.1.1. журамд заасан баримт бичгийг бүрэн гүйцэд ирүүлсэн эсэхийг шалгах;

3.1.2. үүсгэн байгуулагч /үүсгэн байгуулагчид/ нь дүрмийн санд хувь хөрөнгө оруулах, хувьцаа худалдаж авах талаар хүлээсэн үүргээ үүсгэн байгуулах гэрээнд заасан хугацаанд биелүүлснийг нотлох төлбөрийн баримт болон адилтгах бусад баримт байгаа эсэх, үүсгэн байгуулагч /үүсгэн байгуулагчид/-аас ББСБ-ын дүрмийн санд хувь хөрөнгө оруулахаар тохиролцсон хөрөнгийн эх үүсвэр нь тухайн үүсгэн байгуулагч /үүсгэн байгуулагчид/-ийн үйл ажиллагаанаас олсон цэвэр ашиг мөн эсэхийг шалган тогтоох;

3.1.3. ББСБ-ын бизнес төлөвлөгөө нь тухайн нутаг дэвсгэрийн хүн амын нягтрал, бичил санхүүгийн үйлчилгээний нэр төрөл, хэмжээ, эх үүсвэр татах, хөрөнгө байршуулах бодит шаардлага, гадаад дотоод хүчин зүйлсийг харгалзан ББСБ-ын эрхлэх үйл ажиллагаа, үйлчилгээний хамрах хүрээнд тодорхойлж, тооцоолсон болон ББСБ-ыг байгуулснаар үүсгэн байгуулагч /үүсгэн байгуулагчид/-ийн хөрөнгө болон бусад эх үүсвэрийг төвлөрүүлэн үр ашигтайгаар байршуулах замаар ашигтай ажиллаж чадахыг нотолж байгаа эсэх, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлснээр санхүүгийн салбар, эдийн засгийн хөгжлийг тогтворжуулах, хурдцад нөлөөзүүлэхийг хэрхэн тусгасан талаар шалгаж, дүгнэлт гаргах;

3.1.4. үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах дүрэм, журам, заавар нь хууль тогтоомжид нийцсэн эсэх;

3.1.5. ББСБ-ын үүсгэн байгуулагч /үүсгэн байгуулагчид/, ТУЗ-ийн дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлага болон ажиллах боловсон хүчин нь банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах хууль, ёс зүйн шаардлага болон мэдлэг мэргэжил, ажлын ур чадварын шалгуурыг хангаж байгаа эсэх;

3.1.6. техник, тоног төхөөрөмж, программ хангамж, ажлын байр нь банк бус санхүүгийн үйл ажиллагааг найдвартай, аюулгүй эрхлэх наад захын шаардлагыг хангасан, харуул хамгаалалт нь найдвартай ажиллах боломжтой зэргийг газар дээр нь шалгах;

3.1.7. ББСБ-ын хяналтын тогтолцоо, ажиллах зарчим нь дотоод хяналтад тавих наад захын шаардлагыг хангахуйцаар зохион байгуулагдсан болон ББСБ-д учирч болзошгүй эрсдэлийг зөв тодорхойлж, үнэлж дүгнэх чадвартай эсэх, хяналтыг удирдлагын шат бүрт хэрэгжүүлэх давхар хяналтын системийг бүрдүүлж, хүлээх эрх, үүрэг, хариуцлагыг хууль тогтоомжид заасны дагуу тодорхой тусгаж чадсан эсэх, дотоод хяналтын албаны удирдлага, ажилтан нь ийм мэдлэг, чадвар, туршлагатай эсэхийг шалган тогтоох.

3.2. Хороо шаардлагатай гэж үзсэн асуудлаар хууль хяналт, татвар, аудит, банк, бусад байгууллагаас тодорхойлолт, лавлагаа гаргуулна.

3.3. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохыг хүсч ирүүлсэн баримт бичгийг хянан үзсэний үндсэн дээр бүрдэл дутуу, хангалтгүй гэж үзвэл энэ талаар үүсгэн байгуулагч /үүсгэн байгуулагчид/-д албан ёсоор мэдэгдэж, шаардлагатай нэмэлт баримт бичгийг шаардаж авна.

3.4. Ирүүлсэн баримт бичиг нь бүрдэл дутуу, шаардлага хангаагүй, баримт бичгийг зайлшгүй магадлан шинжлэх, нэмж тодруулах шаардлагатай болүүсгэн байгуулагч /үүсгэн байгуулагчид/-д нэмж засвар өөрчлөлт хийх, нөхөн бүрдүүлэх талаар Хороо албан бичгээр мэдэгдэх ба баримт бичгийг бүрэн гүйцэд, үнэн зөв бүрдүүлж ирүүлсэн өдрөөс эхлэн шийдвэрлэх ажлын хоногийн хугацааг тооцно.

3.5. Хорооны хуралдаан болох өдрөөс өмнө ББСБ-ын дүрмийн санг бүрдүүлэх мөнгөн хөрөнгийг Хорооны дансанд байршуулахыг үүсгэн байгуулагч /үүсгэн байгуулагчид/-д албан бичгээр мэдэгдсэний дагуу холбогдох дансанд төвлөрүүлсэн байна. Энэхүү мөнгөн хөрөнгөд Хороо хүү төлөхгүй.

3.6. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн баримт бичгийг хянах хугацаа нь Хороонд анх хүсэлт гаргасан өдрөөс хойш 3 сараас илүүгүй байна.

3.7. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн баримт бичгийг дээрх хугацаанд бүрэн ирүүлээгүй бол хүсэлтийг буцаана.

**ДӨРӨВ. БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, СУНГАХ, ОЛГОХООС ТАТГАЛЗАХ**

/Гарчгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 208 дугаар тогтоолоор өөрчилсөн/

/Гарчгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 533 дугаар тогтоолоор өөрчилсөн./

4.1. Үүсгэн байгуулагч /үүсгэн байгуулагчид/-аас банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохыг хүсч ирүүлсэн баримт бичгийг хууль тогтоомж, энэхүү журмын дагуу хянаж, холбогдох санал дүгнэлт гарган, Хорооны хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

4.2. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг улсын эдийн засгийн байдал, мөнгөний ханшны өөрчлөлт, төлбөрийн чадварыг харгалзан Хорооноос баримталж буй бодлогод тулгуурлан аль нэгэн тодорхой нэр төрлийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохгүй байхаар шийдвэрлэж болно.

4.3. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох шийдвэрт тухайн ББСБ-д ямар нэр төрлийн банк бус санхүүгийн үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл олгосныг тусгана. Хэрэв банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тодорхой хугацаагаар олгож байгаа бол энэ тухай заана.

4.4. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон тухай шийдвэрийг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгож, нэгдсэн бүртгэлд бүртгэн, зохих зааврын дагуу хувийн хэрэг нээн хөтөлнө.

4.5. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох шийдвэр хэлбэржин гарсны дараа ББСБ-ын албан бичгээр ирүүлсэн хүсэлт, нэхэмжлэлийн баримтыг үндэслэн ББСБ-ын дүрмийн сангийн мөнгөн хөрөнгийг ББСБ-ын харилцах данс руу шилжүүлнэ.

4.6. Хорооноос үүсгэн байгуулагч /үүсгэн байгуулагчид/-д ББСБ байгуулж, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосны дараа Үндэсний татварын ерөнхий газрын Улсын бүртгэлийн албанд бүртгүүлж, холбогдох баталгаажилтыг хийлгэснээр үйл ажиллагаагаа эхлүүлэх ба ББСБ-ын нотариатаар гэрчлүүлсэн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, дүрэм, холбогдох журмуудын эх хувь, эсвэл, нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, Монголбанкны Зээлийн мэдээллийн сантай байгуулсан хамтран ажиллах гэрээг ирүүлнэ.

4.7. Хороо нь үүсгэн байгуулагч /үүсгэн байгуулагчид/-аас ББСБ байгуулж, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн баримт бичиг нь энэхүү журмын 2.3, 2.4-д дурдсан нөхцөл, шаардлагыг хангаагүй буюу дараах үндэслэлээр тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана. Үүнд:

4.7.1. дүрмийн сангийн мөнгөн хөрөнгийг зээлээр бүрдүүлсэн нь нотлогдсон;

4.7.2. банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн нь нотлогдсон;

4.7.3. үүсгэн байгуулагч /үүсгэн байгуулагчид/, ТУЗ-ийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал нь зээлийн гэрээ буюу баталгаагаар хүлээсэн, хугацаа хэтэрсэн аливаа өртэй;

4.7.4. үүсгэн байгуулагч /үүсгэн байгуулагчид/, гүйцэтгэх удирдлага, ажиллах боловсон хүчин нь гэмт хэрэгт шалгагдаж байгаа болон шүүхийн шийтгэх тогтоолоор ял шийтгэл эдэлж байгаа нь тогтоогдсон;

4.7.5. үүсгэн байгуулагч /үүсгэн байгуулагчид/, ТУЗ-ийн дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлагын ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь ББСБ-ыг удирдахад харшилна гэж үзсэн;

4.7.6. банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн баримт бичгийг бүрэн гүйцэд, энэхүү журмын шаардлагад нийцэхүйц хэмжээнд бүрдүүлэх хугацаа нь хүсэлт тавьсан өдрөөс хойш 6 сарын хугацаа өнгөрсөн;

4.7.7. энэ журамд заасан бусад нөхцөл, шаардлагыг хангаагүй.

4.8. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд Хороо энэ талаарх тайлбарыг үүсгэн байгуулагч /үүсгэн байгуулагчид/-д албан бичгээр мэдэгдэнэ.

4.9. Хуурамч баримт бичиг бүрдүүлсэн гэдэг үндэслэлээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохоос Хороо татгалзсан тохиолдолд уг өдрөөс хойш 1 жилийн дотор тухайн үүсгэн байгуулагч /үүсгэн байгуулагчид/-аас банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлтийг дахин хүлээж авахгүй.

~~4.10 Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тус үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэн эрхлэхийг хүсвэл тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 60 хоногийн өмнө тусгай зөвшөөрлөө сунгуулах хүсэлтээ Хороонд албан бичгээр гаргана. Хүсэлтээ гаргахдаа энэ журмын дагуу бичиг баримтаа бүрдүүлж, хавсарган ирүүлнэ.~~

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 208 дугаар тогтоолоор нэмсэн/

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 533 дугаар тогтоолоор хассан./

~~4.11 Тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хариуцан ажилладаг Хорооны хянан шалгагч уг компанийн тусгай зөвшөөрөл дуусахаас 60 хоногийн өмнө газрын даргын албан бичгээр тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд энэ тухай мэдэгдэнэ.~~

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 208 дугаар тогтоолоор нэмсэн/

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 533 дугаар тогтоолоор хассан./

~~4.12 Ийнхүү тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ журмын 4.1-д заасан хугацаанд Хороонд хүсэлтээ ирүүлээгүй тохиолдолд хариуцсан хянан шалгагч тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө хугацаа нь дуусч байгаа болон хүчингүй болсонд төөцөх бөлөхыг анхааруулсан мэдэгдэл хүргүүлнэ.~~

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 208 дугаар тогтоолоор нэмсэн/

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 533 дугаар тогтоолоор хассан./

~~4.13 Тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлөө сунгуулах хүсэлтээ холбогдох баримт бичгээ ирүүлээгүй тохиолдолд Хорооны хянан шалгагч тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан өдрөөс эхлэн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг түр зогсоож, тусгай зөвшөөрлийг хүчингүй болсонд тооцуулахаар Хорооны хуралдаанд оруулж шийдвэрлүүлнэ.~~

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 208 дугаар тогтоолоор нэмсэн/

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 533 дугаар тогтоолоор хассан./

ТАВ. БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ НЭМЖ ОЛГОХ

5.1. Хороо дараах нөхцөл, шаардлагыг хангасан ББСБ-д тодорхой нэр төрлийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нэмж олгож болно. Үүнд:

5.1.1. холбогдох хууль тогтоомж, журам, зааварт заасан шаардлагыг бүрэн хангасан;

5.1.2. Хорооноос хийсэн газар дээрх шалгалтаар сайн болон хангалттай үнэлгээ авсан, шалгалтын дүнгээр өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангагдсан;

5.1.3. Хорооноос баталсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг 6 ба түүнээс дээш сарын хугацаанд хангаж, үйл ажиллагаагаа хэвийн явуулсан;

5.1.4. санхүү, төлбөрийн чадвар, нэр хүнд болон хувь нийлүүлэгчдийн бизнесийн ёс зүй нь уг үйл ажиллагааг эрхлэхэд харшлахгүй гэж үзсэн;

5.2. Тодорхой нэр төрлийн банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нэмж эрхлэхийг хүссэн ББСБ дараах баримт бичгийг Хороонд ирүүлнэ. Үүнд:

5.2.1. энэхүү журмын нэгдүгээр хавсралтын дагуу тодорхой нэр төрлийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдөл;

5.2.2. тодорхой нэр төрлийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тухай хувь нийлүүлэгчдийн хурлын тэмдэглэл, шийдвэр, дүрмийн санд нэмж шаардагдах мөнгөн хөрөнгийн хэмжээ;

5.2.3. нэмэлт өөрчлөлт оруулсан дүрмийн эх хувь;

5.2.4. нэмэлт өөрчлөлт оруулсан бизнес төлөвлөгөө, санхүүгийн үр ашгийн тооцоо;

5.2.5. шинээр эрхлэх тодорхой нэр төрлийн банк бус санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх журмын эх хувь.

5.3. Тодорхой нэр төрлийн банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нэмж эрхлэхийг хүссэн ББСБ-аас ирүүлсэн 5.2-т дурдсан баримт бичгийг хянах эрх бүхий газар холбогдох хууль тогтоомж, журмын дагуу хянаж, тухайн тодорхой нэр төрлийн үйл ажиллагаа нь ББСБ-ын санхүүгийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, харилцагчдад нь хохирол учруулахгүй, боловсон хүчин, техник тоног төхөөрөмж, программ хангамж нь тухайн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцлийг хангасан гэж үзвэл холбогдох санал дүгнэлт гарган, Хорооны хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

5.4. Хорооноос тодорхой нэр төрлийн банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нэмж олгосон тухай ББСБ-ын тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад зохих тэмдэглэгээг хийж, баталгаажуулсны дараа ББСБ нь Үндэсний татварын ерөнхий газрын Улсын бүртгэлийн албанд холбогдох бүртгэлийг хийлгэн, ББСБ-ын нотариатаар гэрчлүүлсэн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, шинэчилсэн буюу өөрчлөлт оруулсан дүрэм, холбогдох журмуудын эх хувь, эсвэл нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг ирүүлнэ.

5.5. Хороо тодорхой нэр төрлийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж олгохоос татгалзсан тохиолдолд энэ тухай албан бичгийг ББСБ-д хүргүүлнэ.

5.6. Хорооноос тодорхой нэр төрлийн банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нэмж олгохоос татгалзсан үндэслэлийн дагуу холбогдох зөрчил, дутагдлыг арилгасны дараа тухайн ББСБ-аас тодорхой нэр төрлийн банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нэмж эрхлэх хүсэлтийг дахин хүлээн авч болно.

ЗУРГАА. ДҮРМИЙН САНГИЙН ХЭМЖЭЭ, БҮТЭЦ, ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН БҮРЭЛДЭХҮҮНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХАД ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ

6.1. ББСБ нь дүрмийн сангийн хэмжээ, бүтэц, хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар өөрчилнө. Үүнд:

6.1.1. хувь нийлүүлэгч /хувь нийлүүлэгчид/-ээс банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх явцад бий болсон хуримтлагдсан ашгаар нэмж хөрөнгө оруулах;

6.1.2. хувь нийлүүлэгч /хувь нийлүүлэгчид/-ээс банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх явцад бий болсон хуримтлагдсан ашгаас бусад мөнгөн хөрөнгөөр нэмж оруулах;

6.1.3. шинээр хувь нийлүүлэгч элсүүлэх, хувьцаа гаргах замаар;

6.1.4. хувь нийлүүлэгч /хувь нийлүүлэгчид/-ийн оруулсан мөнгөн хөрөнгийг бусдад өвлүүлэх, бэлэглэх, гэрээслэх замаар дүрмийн сангийн бүтэц, хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах;

6.1.5. холбогдох хууль тогтоомжийг зөрчихгүй, хувь нийлүүлэгч /хувь нийлүүлэгчид/ дүрмийн санд оруулсан хувь хөрөнгийнхөө хэмжээгээр санхүүгийн хариуцлага хүлээж, алдагдлыг нөхөх тухай хариуцлагаас зайлсхийсэн гэж үзэх үндэслэлгүй, дүрмийн сангийн доод хэмжээг хангах боломжтой, санхүү, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулснаар бусад хувь нийлүүлэгч, харилцагчдад хохирол учруулахгүй бол ББСБ-ын дүрмийн сангийн хэмжээг хорогдуулах;

6.2. ББСБ нь дүрмийн сангийн хэмжээ, бүтэц, хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд орох өөрчлөлтийг тухай бүр Хороонд мэдэгдэж, зөвшөөрөл авахдаа дээрх өөрчлөлтийн дагуу аливаа гүйлгээ, төлбөр хийхээс өмнө дараах баримт бичгийг Хороонд ирүүлнэ. Үүнд:

6.2.1. хүсэлт тавьсан албан бичиг;

6.2.2. өөрчлөлт оруулах болсон хууль зүйн үндэслэлийг нотлох баримт бичиг буюу хувьцаа шинээр буюу нэмж гаргах, эзэмшиж буй хувьцааг бусдад худалдахыг зөвшөөрсөн хувь нийлүүлэгчдийн хурлын тэмдэглэл, шийдвэр, худалдсан тухай ББСБ-ын болон биржийн мэдээ, холбогдох гэрээ хэлцэл, эсхүл Иргэний хуулийн дагуу өмчлөх эрхээ өвлүүлсэн, бэлэглэсэн, гэрээсэлснийг нотлох баримт бичиг;

6.2.3. ББСБ-ын дүрмийн санд хувь нийлүүлэн шинээр орж буй хувь нийлүүлэгч /хувь нийлүүлэгчид/-ийн хувьд энэхүү журмын хоёрдугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт, 2.3.11а, 2.3.11б-д заасан холбогдох байгууллагаас авсан тодорхойлолт, журмын 2.3.11в, 2.4.3-д заасан баримт бичиг, мэдээлэл болон дүрмийн санд оруулах мөнгөн хөрөнгийн гарал үүсэл, хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаанаас олсон орлогоос бүрдэж буйг нотлох баримт бичиг;

6.2.4. үүсгэн байгуулагчдын хамтран ажиллах гэрээ, дүрмийн сангийн хэмжээ, бүтэц, хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахтай холбогдуулан ББСБ-ын дүрэмд орох нэмэлт өөрчлөлтүүд;

6.2.5. ХК хэлбэрээр үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын хувьд хувьцааны эзэмшигч өөрчлөгдсөн тухай “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иас ирүүлсэн тодорхойлолт, хувьцаа эзэмшигч /эзэмшигчид/-ийн дансны үлдэгдэл бүхий хуулга;

6.2.6. Хороо шаардлагатай гэж үзвэл мөнгө угаах, алан хядах ажиллагааг санхүүжүүлэхийн эсрэг арга хэмжээний тухай хууль тогтоомжид заасан мэдээлэл, тодорхойлолт болон бусад.

6.3. Хорооны банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн баримт бичгийг хянах эрх бүхий газрын санал, дүгнэлтээр дүрмийн сангийн мөнгөн хөрөнгийг нэмэгдүүлэхтэй холбоотой энэ журмын 6.2-д заасан баримт бичиг нь зохих нөхцөл, шаардлага хангасан гэж үзээд Хорооны даргад санал оруулахаас өмнө дүрмийн санг нэмэгдүүлэх мөнгөн хөрөнгийг Хорооны дансанд байршуулахыг тухайн ББСБ-д албан бичгээр мэдэгдсэний дагуу холбогдох дансанд төвлөрүүлсэн байх ба энэхүү мөнгөн хөрөнгөд Хороо хүү төлөхгүй.

6.4. Дүрмийн сангийн хэмжээ, бүтэц, хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах зөвшөөрөл хүсч ББСБ-аас ирүүлсэн хүсэлт, холбогдох баримт бичгийг хянаж, шаардлагатай асуудлыг газар дээр нь шалгасны үндсэн дээр санал, дүгнэлт гарган Хорооны даргад танилцуулж, шийдвэрлүүлнэ.

6.5. Дүрмийн сангийн хэмжээг нэмэгдүүлэх зөвшөөрөл олгох шийдвэр хэлбэржин гарсны дараа ББСБ-ын албан бичгээр ирүүлсэн хүсэлт, нэхэмжлэлийн баримтыг үндэслэн дүрмийн санг нэмэгдүүлэх мөнгөн хөрөнгийг ББСБ-ын харилцах данс руу шилжүүлнэ.

6.6. Дүрмийн сангийн хэмжээ, бүтэц, хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах зөвшөөрөл Хорооноос олгож, ББСБ-ын тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад зохих тэмдэглэгээг хийн, баталгаажуулсны дараа ББСБ нь Үндэсний татварын ерөнхий газрын Улсын бүртгэлийн албанд холбогдох бүртгэлийг хийлгэн, ББСБ-ын нотариатаар гэрчлүүлсэн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, шинэчилсэн буюу өөрчлөлт оруулсан дүрмийн эх хувь /эсвэл, нотариатаар гэрчлүүлсэн хуулбар/ болон Хороо шаардлагатай гэж үзвэл холбогдох журмуудын эх хувь /эсвэл, нотариатаар гэрчлүүлсэн хуулбар/-ийг ирүүлнэ.

6.7. Дүрмийн сангийн хэмжээг хувь нийлүүлэгч /хувь нийлүүлэгчид/-ээс банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх явцад бий болсон хуримтлагдсан ашгаар нэмэгдүүлэх тохиолдолд энэхүү журмын 6.3, 6.5 дахь заалтууд хамаарахгүй бөгөөд Хорооноос зөвшөөрөл олгосны дараа ББСБ нь дүрмийн санг нэмэгдүүлэх гүйлгээг хийсэн холбогдох нягтлан бодох бүртгэлийн баримт, хуулгыг Хороонд ирүүлнэ.

6.8. Хороо ББСБ-ын дүрмийн сангийн хэмжээ, бүтэц, хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахад зөвшөөрөл олгох эсэхийг хуанлийн 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.

ДОЛОО. ХОЁРДОГЧ ӨГЛӨГИЙН ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ОЛГОХООС ТАТГАЛЗАХ

7.1. “ББСБ-ын хоёрдогч өглөг” гэж гэрээнд заасан хугацаа дууссаны эцэст хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрийг үндэслэн хувьцаагаар солих бөгөөд энэ талаар холбогдох гэрээнд тодорхой заасан байх өрийн бичгийг хэлнэ.

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 01 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан./

7.2. ББСБ-ын хоёрдогч өглөгийн үндсэн өрийг ББСБ-ыг татан буулгасан, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон, дампуурсан, төлбөрийн чадваргүй болсныг зарласан, өөрчлөн байгуулсан, Хорооноос урьдчилан зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд хугацаанаас нь өмнө барагдуулахыг хориглоно.

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 01 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан./

7.3. Хоёрдогч өглөгөөр эх үүсвэр татах тухай бүр Хороонд мэдэгдэж, зөвшөөрөл авахдаа аливаа гүйлгээ, төлбөр хийхээс өмнө дараах баримт бичгийг Хороонд ирүүлнэ. Үүнд:

7.3.1. хүсэлт тавьсан албан бичиг;

7.3.2. хоёрдогч өглөгөөр эх үүсвэр татах болсон хууль зүйн үндэслэлийг нотлох баримт бичиг буюу хувь нийлүүлэгчдийн хурлын тэмдэглэл, шийдвэр, хоёрдогч өглөгийн гэрээ;

7.3.3. хоёрдогч өглөгийн гэрээгээр хөрөнгө оруулагч иргэн, хуулийн этгээдийн энэхүү журмын хоёрдугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт болон дараах баримт бичиг, тодорхойлолтууд. Үүнд:

а/ татварын байгууллагад өр төлбөртэй эсэх талаарх эдгээр байгууллагын удирдлагын гарын үсэг бүхий тодорхойлолт;

б/ ял шийтгэлтэй эсэх талаарх Цагдаагийн ерөнхий газрын тухайн асуудал хариуцсан хэлтэс, тасгийн удирдлагын гарын үсэг бүхий тодорхойлолт.

в/ иргэний үнэмлэхийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар.

7.3.4. мөнгөн хөрөнгийн гарал үүсэл, хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаанаас олсон орлогоос бүрдэж буйг нотлох баримт бичиг;

7.4. Хоёрдогч өглөгийн зөвшөөрөл хүсч ББСБ-аас ирүүлсэн хүсэлт, холбогдох баримт бичгийг хянаж, шаардлагатай асуудлыг газар дээр нь шалгасны үндсэн дээр санал, дүгнэлт гарган Хорооны даргад танилцуулж, шийдвэрлүүлнэ.

7.5. Хороо ББСБ-аас ирүүлсэн энэхүү журмын 7.3-т дурдсан баримт бичгүүд нь зохих нөхцөл, шаардлагыг хангаагүй үндэслэлээр тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана.

НАЙМ. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭГЖ БАЙГУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ОЛГОХООС ТАТГАЛЗАХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

8.1. ББСБ нь салбар, төлөөлөгчийн газартай байж болох ба тэдгээр нь хуулийн этгээдийн эрхгүй бөгөөд үйл ажиллагаагаа ББСБ-аас олгосон итгэмжлэлийн үндсэн дээр явуулах ба зөвхөн тухайн ББСБ-ын оноосон нэрийг хэрэглэнэ.

8.2. ББСБ-ын оршин байгаа газраас өөр газар байрлаж, түүний эрхлэх тусгай зөвшөөрөлтэй банк бус санхүүгийн үйл ажиллагааг эрхэлж буй нэгжийг салбар гэнэ.

8.3. ББСБ-ын оршин байгаа газраас өөр газар байрлаж, түүний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах буюу түүний нэрийн өмнөөс хэлцэл болон эрх зүйн бусад үйлдэл хийх үүрэг бүхий нэгжийг төлөөлөгчийн газар гэнэ.

8.4 ББСБ-ын нэгж байгуулах зөвшөөрлийг Хорооноос олгох ба нэгж тус бүр нь зөвшөөрлийн гэрчилгээтэй байна.

8.5. ББСБ нэгж байгуулах хүсэлт гаргахдаа дараах баримт бичгийг бүрдүүлж, Хороонд ирүүлнэ. Үүнд:

8.5.1. хүсэлт тавьсан албан бичиг;

8.5.2. тухайн нэгжийн үйл ажиллагаа явуулах хүрээ, бүх эрсдэлийг ББСБ хариуцах тухай хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр;

8.5.3. ББСБ-ын дүрмийн холбогдох өөрчлөлт, нэгж байгуулах, түүний эрх, үүрэг, өөрчлөн байгуулах, татан буулгах болон бусад харилцааг зохицуулсан нэгжийн үйл ажиллагаанд мөрдөх журам;

8.5.4. нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих тухай дотоод хяналтын журамд орсон нэмэлт өөрчлөлт /хэрэв дотоод хяналтын албаны эрх, үүрэг, хариуцлага нь дүрмийн заалтаар зохицуулагддаг бол дүрэмд орсон өөрчлөлт/;

8.5.5. энэхүү журмын гуравдугаар хавсралтын дагуу гаргасан нэгжид ажиллах боловсон хүчний тодорхойлолт болон дараах баримт бичиг, тодорхойлолтууд. Үүнд:

а/ татварын байгууллагад өр төлбөртэй эсэх талаарх эдгээр байгууллагын удирдлагын гарын үсэг бүхий тодорхойлолт;

б/ ял шийтгэлтэй эсэх талаарх Цагдаагийн ерөнхий газрын тухайн асуудал хариуцсан хэлтэс, тасгийн удирдлагын гарын үсэг бүхий тодорхойлолт.

в/ иргэний үнэмлэх, мэргэжлийн дипломын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар.

8.5.6. энэхүү журмын дөрөвдүгээр хавсралтын дагуу гаргасан нэгжийн техник тоног төхөөрөмж, программ хангамж, ажлын байрны тодорхойлолт, түүнд техник тоног төхөөрөмж, программ хангамж, ажлын байрны найдвартай, аюулгүй ажиллагаа, нууцлал, харуул, хамгаалалтын асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар тусгаж, дурдсан шаардлагын талаар бусад этгээдтэй байгуулсан гэрээ эсхүл нотариатын байгууллагаар гэрчлүүлсэн гэрээний хуулбар;

8.6. ББСБ-аас нэгж байгуулахаар хүсч ирүүлсэн энэхүү журмын 8.5-д дурдсан баримт бичгийг хянаж, нэгж байгуулах нь тухайн ББСБ-ын санхүүгийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, боловсон хүчин, техник тоног төхөөрөмж, программ хангамж нь тухайн нэгжийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл, шаардлагыг хангаж байна гэж үзвэл шаардлагатай асуудлыг газар дээр нь шалгасны үндсэн дээр санал, дүгнэлт гарган Хорооны даргад танилцуулж, шийдвэрлүүлнэ.

8.7. ББСБ-ын нэгж байгуулахыг зөвшөөрсөн Хорооны даргын шийдвэр, холбогдох журамд зааснаар ББСБ-аас төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны дансанд төлсөн баримтыг тус тус үндэслэн нэгжийн зөвшөөрлийн гэрчилгээг олгоно.

8.8. Хороо ББСБ-ын тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад холбогдох тэмдэглэгээг хийж, баталгаажуулсны дараа ББСБ нь Үндэсний татварын ерөнхий газрын Улсын бүртгэлийн албанд холбогдох бүртгэлийг хийлгэн, ББСБ-ын нотариатаар гэрчлүүлсэн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, шинэчилсэн буюу өөрчлөлт оруулсан дүрмийн эх хувь /эсвэл, нотариатаар гэрчлүүлсэн хуулбар/ болон Хороо шаардлагатай гэж үзвэл холбогдох журмуудын эх хувь /эсвэл, нотариатаар гэрчлүүлсэн хуулбар/-ийг ирүүлнэ.

8.9. ББСБ нь нэгжийг татан буулгах, үйл ажиллагааг нь хязгаарлах, өөрчлөн байгуулах, байршлыг нь өөрчлөх /ББСБ-ын төв байр, салбар, төлөөлөгчийн газрын байршлыг өөр нэгжид болон өөр хооронд нь солих, шилжүүлэх/ тухай бүрт шийдвэр гаргаж, уг шийдвэрийг гаргасан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор Хороонд албан бичгээр мэдэгдэх ба ингэхдээ тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтын эх хувийг ирүүлж, холбогдох тэмдэглэгээ, бүртгэлийг хийлгэнэ.

8.10. Нэгж байгуулах зөвшөөрөл хүссэн ББСБ нь дараах нөхцөл, шаардлагыг хангаагүй тохиолдолд нэгж байгуулах зөвшөөрөл олгохоос Хороо татгалзана. Үүнд:

8.10.1. Хорооноос хийсэн газар дээрх шалгалтаар хангалтгүй болон муу үнэлгээ авсан, шалгалтын дүнгээр өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүй;

8.10.2. Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг 3 сар дараалан хангаж ажиллаагүй;

8.10.3. нэгжийн зөвшөөрөл хүсч ирүүлсэн баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн нь нотлогдсон;

8.10.4. нэгжийн удирдлагын ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь нэгжийг удирдахад харшилна гэж үзсэн;

8.10.5. нэгжийн зөвшөөрөл хүсч ирүүлсэн баримт бичгийг бүрэн гүйцэд, энэхүү журмын шаардлагад нийцэхүйц хэмжээнд бүрдүүлэх хугацаа нь анх хүсэлт тавьсан өдрөөс хойш 3 сарын хугацаа өнгөрсөн;

8.10.6. энэ журамд заасан бусад нөхцөл, шаардлагыг хангаагүй.

8.11. Нэгжийн зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд Хороо ББСБ-д албан бичгээр мэдэгдэнэ.

8.12. Хорооноос нэгжийн зөвшөөрөл олгохоос татгалзсан үндэслэлийн дагуу холбогдох зөрчил, дутагдлыг арилгасны дараа тухайн ББСБ-аас нэгжийн зөвшөөрлийн хүсэлтийг дахин хүлээж авч болно.

8.13. Хуурамч баримт бичиг бүрдүүлсэн гэдэг үндэслэлээр нэгжийн зөвшөөрөл олгохоос Хороо татгалзсан тохиолдолд уг өдрөөс хойш 6 сарын дотор ББСБ-аас нэгжийн зөвшөөрөл хүссэн хүсэлтийг дахин хүлээж авахгүй.

8.14. ББСБ-ын нэгжийн зөвшөөрлийг дараах үндэслэлээр хязгаарлаж, нэгжийн үйл ажиллагааг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ. Үүнд:

8.14.1. тухайн нэгжийн үйл ажиллагаа нь ББСБ-ын санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна гэж үзсэн;

8.14.2. ББСБ нь Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг 6 сар дараалан хангаж ажиллаагүй;

8.14.3. Хорооноос хийсэн газар дээрх шалгалтаар хангалтгүй болон муу үнэлгээ авсан;

8.14.4. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

8.15. Нэгжийн зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тохиолдолд ББСБ нь түдгэлзүүлсэн үндэслэл болсон зөрчил дутагдлыг арилгаж хэвийн үйл ажиллагаагаа хангасан гэж үзвэл тухайн ББСБ-ын нэгжийн зөвшөөрлийг сэргээлгэх хүсэлтийг Хороонд гаргана.

8.16. Нэгжийн зөвшөөрлийг дараах үндэслэлээр хүчингүй болгож зөвшөөрлийн гэрчилгээг хураан авна. Үүнд:

8.16.1. нэгжийг татан буулгах ББСБ-ын удирдлагын шийдвэр;

8.16.2. Холбогдох хууль тогтоомжид нийцээгүй үйл ажиллагаа явуулсан, Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй болон нэгжийн үйл ажиллагаа нь тухайн ББСБ-ын хэвийн үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн чадварт хүндрэл учруулахаар байгааг тогтоосны үндсэн дээр гаргасан Хорооны даргын шийдвэр;

8.16.3. Хорооноос нэгжийн зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд сэргээлгэх тухай хүсэлтийг ирүүлээгүй;

8.16.4. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

8.17. ББСБ-ын нэгжийн зөвшөөрлийг шинээр олгохоос Хороо татгалзсан болон тухайн ББСБ-ын нэгжийн зөвшөөрлийг хүчингүй болгосон үндэслэлийн дагуу холбогдох зөрчил, дутагдлыг арилгасны дараа ББСБ-аас нэгжийн зөвшөөрөл нэмж хүссэн өргөдлийг Хороонд дахин ирүүлж болно.

ЕС. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ОНООСОН НЭР ӨӨРЧЛӨХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ

9.1. ББСБ нь оноосон нэрээ өөрчлөхийг хүсвэл Хороонд өргөдөл гаргах бөгөөд дараах баримт бичгийг бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:

9.1.1. хүсэлт тавьсан албан бичиг;

9.1.2. ББСБ-ын оноосон нэр өөрчлөх тухай хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр;

9.1.3. Үндэсний татварын ерөнхий газрын Улсын бүртгэлийн албанаас авсан хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтын хуудас;

9.1.4. ББСБ-ын өөрчлөлт оруулсан дүрмийн эх хувь;

9.1.5. ББСБ-ын тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, гэрчилгээний хавсралтын эх хувь;

9.1.6. бусад шаардлагатай баримт материал.

9.2. ББСБ-ын оноосон нэр солих хүсэлтийг хянаж, оноосон нэрийг өөрчлөх нь ББСБ-ын харилцагчдад сөргөөр нөлөөлөхгүй, төөрөгдүүлэхгүй гэж үзвэл тухайн ББСБ-ын оноосон нэрийг өөрчлөхийг зөвшөөрсөн тухай шийдвэрийг Хорооны дарга гаргана.

9.3. ББСБ-ын оноосон нэр өөрчлөхийг зөвшөөрсөн Хорооны даргын шийдвэр, холбогдох журамд зааснаар ББСБ-аас төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны дансанд төлсөн баримтыг тус тус үндэслэн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээг шинэчлэн олгож, холбогдох тэмдэглэгээг хийн баталгаажуулсны дараа ББСБ нь Үндэсний татварын ерөнхий газрын Улсын бүртгэлийн албанд холбогдох бүртгэлийг хийлгэн, ББСБ-ын нотариатаар гэрчлүүлсэн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, шинэчилсэн буюу өөрчлөлт оруулсан дүрэм болон холбогдох журмуудын эх хувь, эсвэл, нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг ирүүлнэ.

АРАВ. БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, СЭРГЭЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

10.1. Хороо нь банк бус санхүүгийн тодорхой нэр төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ. Үүнд:

10.1.1. тухайн үйл ажиллагааны ирүүлбэл зохих санхүүгийн тайлан, мэдээг 6 сар дараалан Хороонд ирүүлээгүй;

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 532 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан./

10.1.2. Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллахад сөргөөр нөлөөлсөн тодорхой нэр төрлийн үйл ажиллагаанаас хамаарч 6 сар дараалан хангаж ажиллаагүй бол тухайн тодорхой нэр төрлийн үйл ажиллагааг;

10.1.3. Хорооноос хийсэн газар дээрх шалгалтаар хангалтгүй болон муу үнэлгээ авсан;

10.1.3¹ тухайн төрлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг авснаас хойш 3 улирал дараалан үйл ажиллагаа эрхлээгүй;

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 532 дугаар тогтоолоор нэмсэн/

10.1.4. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

10.2. Хороо нь банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ. Үүнд:

10.2.1. Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг 9 сар дараалан хангаж ажиллаагүй;

10.2.2. ирүүлбэл зохих санхүүгийн тайлан мэдээг 6 сар дараалан Хороонд гаргаж өгөөгүй;

10.2.3. Хорооноос тогтоосон дүрмийн сангийн доод хэмжээг хангаж ажиллаагүй;

10.2.4. Хорооноос хийсэн газар дээрх шалгалтаар хангалтгүй болон муу үнэлгээ авсан;

10.2.5. Хорооноос тогтоосон зохицуулалтын үйлчилгээний хөлс төлөх хугацааг аливаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 3-аас дээш сараар хэтрүүлсэн;

10.2.6. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

10.3. Банк бус санхүүгийн үйл ажиллагааг түдгэлзүүлсэн тохиолдолд түдгэлзүүлсэн үндэслэл болсон зөрчил дутагдлыг арилгаж хэвийн үйл ажиллагаагаа хангасан гэж үзвэл тухайн ББСБ нь банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг сэргээлгэх хүсэлтийг Хороонд ирүүлнэ.

10.4. Хороо нь банк бус санхүүгийн тодорхой нэр төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр хүчингүй болгоно. Үүнд:

10.4.1. ББСБ өөрөө хүсэлт гаргасан;

10.4.2. Хорооноос хийсэн газар дээрх шалгалтаар хангалтгүй болон муу үнэлгээ авсан;

10.4.3. Хорооноос банк бус санхүүгийн тодорхой нэр төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд сэргээлгэх тухай хүсэлтийг Хороонд ирүүлээгүй;

10.4.3¹ тухайн төрлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг авснаас хойш 4 улирал дараалан үйл ажиллагаа эрхлээгүй;

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 532 дугаар тогтоолоор нэмсэн/

10.4.4. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

10.5. Хороо дараах үндэслэлээр ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно. Үүнд:

10.5.1. ББСБ өөрөө хүсэлт гаргасан;

10.5.2. ББСБ дампуурсан буюу төлбөрийн чадваргүй болсон эсхүл татан буугдсан тухай эрх бүхий байгууллага, хувь нийлүүлэгчдийн хурлаас зарласан;

10.5.3. тусгай зөвшөөрлийг авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

10.5.4. тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

10.5.5. ББСБ нь улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш 1 жилээс дээш хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй;

10.5.6. Хорооноос хийсэн газар дээрх шалгалтаар хангалтгүй болон муу үнэлгээ авсан;

10.5.7. Хорооноос баталж гаргасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн талаарх шаардлагыг 12 сар дараалан хангаж ажиллаагүй;

10.5.8. ирүүлбэл зохих санхүүгийн тайлан мэдээг 9 сар дараалан Хороонд ирүүлээгүй;

10.5.9. Хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээлгэх тухай хүсэлтийг Хороонд ирүүлээгүй;

10.5.10. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

10.6. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд Хороо энэ тухай олон нийтэд мэдээлэн, тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, хүчингүй тэмдэг даран, тухайн ББСБ-ын хувийн хэрэгт хийж, зохих журмын дагуу архивт шилжүүлнэ.

10.7. Хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд тусгай зөвшөөрлийг дахин олгох тухай ББСБ-ын хувь нийлүүлэгчдийн хүсэлтийг 1 жилийн дотор хүлээн авахгүй бөгөөд тогтоосон хугацааны дараа хүсэлт гаргахдаа энэ журамд заасан шаардлагын дагуу холбогдох баримт бичгийг шинээр бүрдүүлж ирүүлнэ.

10.8. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосноос тусгай зөвшөөрөл эзэмшигчид учирсан хохирлыг Хороо хариуцахгүй.

10.9. Хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн шийдвэр гаргасан өдрөөс хойш ББСБ нь дараах үйлдэл хийхийг хориглоно. Үүнд:

10.9.1. шинээр аливаа гэрээ, хэлцэл байгуулах;

10.9.2. тухайн өдрөөс өмнө байгуулсан аливаа гэрээ, хэлцэлд нэмэлт өөрчлөлт оруулах.

10.10. Хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон шийдвэр гаргасан өдрөөс хойш ББСБ нь энэ журмын 10.9 дэх заалтыг даган мөрдөх бөгөөд Компанийн тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасны дагуу татан буулгаж, үйл ажиллагааг нь дуусгавар болгоно.

10.11. Хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон шийдвэр гаргасан өдрөөс хойш тэдгээр үйл ажиллагааг үргэлжлүүлбэл тусгай зөвшөөрөлгүйгээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлсэн гэж үзэж холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

АРВАН НЭГ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

11.1. Холбогдох хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, заавар, шийдвэрийн биелэлт болон санхүүгийн үйл ажиллагаанд Хороо хяналт тавьж, шалгалт хийнэ.

11.2. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

"Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам"-ын 1 дүгээр хавсралт

БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

Огноо:

Хаана: Санхүүгийн зохицуулах хороо,

Засгийн газрын IV байр

Бага тойруу-6,

Улаанбаатар-46,

Монгол Улс.

Хэнээс:
.....
.....

(өргөдөл гаргагч хуулийн этгээдийн хаяг, байршил, утас, факс, электрон шуудангийн хаяг)

.....

/хуулийн этгээдийн нэр/

.....

/ХК, ХХК/

ББСБ-ын үүсгэн байгуулагч /үүсгэн байгуулагчид/ шинээр ББСБ үүсгэн байгуулах зорилгоор хурал хийж, дор дурдсан банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхээр шийдвэрлэсэн болно. Үүнд:

- 1/
- 2/
- 3/
- 4/
- 5/

/банк бус санхүүгийн үйл ажиллагааны төрөл/

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд дараах үүсгэн байгуулагч иргэд, хуулийн этгээд нь тус ББСБ-д хөрөнгө оруулахаар шийдвэрлэв.

№	Овог, нэр <i>/Хуулийн этгээдийн нэр/</i>	Регистрийн дугаар	Иргэний үнэмлэхийн дугаар <i>/Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар/</i>	Хаяг	Хувь нийлүүлэх хөрөнгийн хэмжээ <i>(мянган төгрөгөөр)</i>

ББСБ-ын үүсгэн байгуулагч /үүсгэн байгуулагчид/ нь өөрийн хууль ёсны өмчлөлд байгаа мөнгөн хөрөнгөөр хувь нийлүүлсэн болно.

ББСБ-ын гүйцэтгэх удирдлагад /гүйцэтгэх захирал, нэгжийн удирдлага, ерөнхий нягтлан бодогч, дотоод хяналтын ажилтнууд/ Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13.6-д заасан шаардлагыг хангасан дараах хүмүүс ажиллах болно. Үүнд:

№	Овог, нэр	Одоогийн эрхэлж байгаа ажил	Регистрийн дугаар	Иргэний үнэмлэхийн дугаар	ББСБ-д эрхлэх албан тушаал

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар бүрдүүлж хүргүүлсэн баримт бичгүүдийг Компанийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нийцүүлэн гаргасан Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны дугаар сарын-ны өдрийн дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын шаардлагад нийцүүлэн үнэн зөв бүрдүүлсэн болно. Бүрдүүлсэн баримт бичигт ямарваа худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Өргөдөл, баримт бичгүүдийг хүлээн авч, хянан шийдвэрлэж ББСБ байгуулж, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоно уу.

ББСБ байгуулагдсанаас хойшхи хугацаанд Компанийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай болон бусад холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллах болно.

ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ:

/тамга, тэмдэг/

/ /
/хуулийн этгээдийн нэр/

/ /
/албан тушаал/

/ /
/гарын үсэг/

/ /
/овог, нэр/

"Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам"-ын 2 дугаар хавсралт

ББСБ-ЫН ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧ БОЛОН ТУЗ-ЫН ДАРГА, ГИШҮҮН, ХОЁРДОГЧ ӨГЛӨГИЙН ГЭРЭЭГЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИЙН ТОДОРХОЙЛОЛТ

А. ББСБ-тай ямар холбоотой болохыг тэмдэглэнэ үү.

- 1. Үүсгэн байгуулагч
- 2. Нийт хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг эзэмшигч
- 3. Төлөөлөн удирдах зөвлөлийн
дарга
гишүүн

4. Хөрөнгө оруулагч

Б. Үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагчийн талаар.

1. Үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгч, хөрөнгө оруулагч нь:

Хуулийн этгээд Иргэн

2. ББСБ-д хувь нийлүүлсэн, хөрөнгө оруулсан хөрөнгийн хэмжээ:

Энгийн хувьцаа

Давуу эрхтэй хувьцаа

төгрөг /тоогоор/ /үсгээр/

3. Үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгч, хөрөнгө оруулагч нь хуулийн этгээд бол дараах мэдээллийг үнэн зөв бичиж ирүүлнэ. Үүнд:

- Оноосон нэр:
- Байгуулагдсан он, сар, өдөр:
- Үйл ажиллагаа эрхлэх хугацаа:
- Байршил буюу хаяг:
- Улсын бүртгэлийн дугаар:
- Регистрийн дугаар:
- ТУЗ-ын дарга, гишүүдийн овог нэр:
- Регистрийн дугаар:
- Хувь нийлүүлэгчдийн овог нэр:
- Регистрийн дугаар:
- Эрхэлж буй үйл ажиллагааны төрөл:

.....
.
.....
.

- Хуулийн этгээдийн үйл ажиллагаатай холбогдсон танилцуулга:


/эрхэлж ирсэн үйл ажиллагааг хугацаагаар нь, хараат буюу охин компанитай эсхүл нэгжтэй эсэх, тэдгээрийн болон тухайн байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн үр дүн, байршил, өмчлөлийн байдал, бусад байгууллагад хувь нийлүүлсэн хөрөнгө зэргийг хамруулан бичнэ/.

- Дүрмийн санд болон хоёрдогч өглөгийн гэрээгээр хөрөнгө оруулсан мөнгөн хөрөнгийн тодорхойлолт:

Хуулийн этгээдийн нэр нь ББСБ-ын хувь нийлүүлэгч /хөрөнгө оруулагч/ болж тус ББСБ-ын дүрмийн санд оруулж байгаа /хоёрдогч өглөгийн гэрээгээр хөрөнгө оруулалт хийж байгаа/ / үсгээр / төгрөг нь манай хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаанаас олсон орлогоос бүрдэж байгаа бөгөөд холбогдох материалуудыг үнэн зөвөөр хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэн танайд хүргүүлсэн болохоо нотлохын зэрэгцээ үүнээс үүсэх аливаа эрсдлийг хууль тогтоомжийн дагуу бүрэн хариуцахаа илэрхийлж байна.

4. Үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгч, хөрөнгө оруулагч нь иргэн бол дараах мэдээллийг үнэн зөв бичиж ирүүлнэ:

- Овог, нэр:
- Төрсөн он, сар, өдөр:
- Иргэний харьяалал:
- Гэрийн хаяг:



- Иргэний үнэмлэхийн дугаар:
- Регистрийн дугаар:
- Эрхэлж байгаа ажил:
 - хугацаа:
 - хаяг:
- Боловсролын талаар /Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он	Диплом, гэрчилгээний дугаар

- Ажлын туршлагын талаар:

№	Хаана ажиллаж байсан	Албан тушаал	Ажилд орсон он, сар, өдөр	Ажлаас гарсан он, сар, өдөр	Шалтгаан

5. Хувь нийлүүлэгчийн холбогдох этгээдийн байдал:

№	Таны хэн /юу/ болох	Овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Регистрийн дугаар	Иргэний үнэмлэхийн дугаар	Эрхэлж буй ажил, албан тушаал

.....овогтой миний бие ББСБ-ын хувь нийлүүлэгч /хөрөнгө оруулагч/ нь болж тус ББСБ-ын дүрмийн санд оруулж байгаа /хоёрдогч өглөгийн гэрээгээр хөрөнгө оруулалт хийж байгаа/ / үсгээр ___/ төгрөг нь миний хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаанаас олсон орлогоос бүрдэж байгаа бөгөөд холбогдох материалуудыг үнэн зөвөөр хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэн танайд хүргүүлсэн болохоо нотлохын зэрэгцээ үүнээс үүсэх аливаа эрсдэлийг хууль тогтоомжийн дагуу бүрэн хариуцахаа илэрхийлж байна.

Холбогдох этгээдийн товч танилцуулгад урьд өмнө эрхэлж байсан ажил, төрлийн байдал, аль нэг хуулийн этгээдийг төлөөлдөг эсэх, түүний үйл ажиллагаа, байршил, бусдад өр, зээлтэй эсэх, одоо хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэгдэн шалгагдаж байгаа эсэх зэргийг бичнэ.

“ ” ББСБ-ыг төлөөлж
/албан тушаал/

/ /
/гарын үсэг/


/ /
/овог, нэр/

"Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам"-ын 3 дугаар хавсралт

ББСБ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ, НЭГЖИЙН УДИРДЛАГА БОЛОН БУСАД БОЛОВСОН ХҮЧНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

1. ББСБ-ын гүйцэтгэх захирал, нэгжийн удирдлага бусад боловсон хүчин нь дараах мэдээллийг үнэн зөв бичиж ирүүлнэ:

- овог, нэр:
- эрхлэх албан тушаал:
- төрсөн он, сар, өдөр:
- иргэний харьяалал:
- гэрийн хаяг:
- утасны дугаар:
- иргэний үнэмлэхийн дугаар:
- регистрийн дугаар:
- одоо эрхэлж байгаа ажил:
 - хугацаа:
 - хаяг:
- Боловсролын талаар /Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/



№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он	Диплом, гэрчилгээний дугаар

--	--	--	--	--	--

- Ажлын туршлагын талаар:

№	Хаана ажиллаж байсан	Албан тушаал	Ажилд орсон он, сар, өдөр	Ажлаас гарсан он, сар, өдөр	Шалтгаан

- гүйцэтгэх удирдлага, боловсон хүчний товч танилцуулга (аль нэг хуулийн этгээдийг төлөөлдөг эсэх, түүний үйл ажиллагаа, байршил, банк, ББСБ-тай харьцаж байсан түүх, харилцагч банкууд, өөр аль нэг хуулийн этгээдийн хувь нийлүүлэгч эсэх, бусдад өр, зээлтэй эсэх, одоо хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэгдэн шалгагдаж байгаа эсэх зэргийг бичнэ):

2. Гүйцэтгэх удирдлага, боловсон хүчний холбогдох этгээдийн байдал:

Холбогдох этгээд гэдгийг Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлд тодорхойлсноор ойлгоно.

№	Таны хэн /юу/ болох	Овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Регистрийн дугаар	Иргэний үнэмлэхийн дугаар	Эрхэлж буй ажил, албан тушаал

Холбогдох этгээдийн товч танилцуулгад урьд өмнө эрхэлж байсан ажил, төрлийн байдал, аль нэг хуулийн этгээдийг төлөөлдөг эсэх, түүний үйл ажиллагаа, байршил, бусдад өр, зээлтэй эсэх, одоо хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэгдэн шалгагдаж байгаа эсэх зэргийг бичнэ.

Гүйцэтгэх удирдлага боловсон хүчний талаарх хууль хяналт, татвар, аудит, банк болон бусад холбогдох хуулийн этгээд, байгууллага, иргэдээс гаргуулан авсан тодорхойлолт, лавлагаа зэргийг хавсаргав.

“ ” ББСБ-ыг төлөөлж
 .

/албан тушаал/

/...../
/гарын үсэг/

/...../
/овог, нэр/

“Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 4 дүгээр хавсралт

ПРОГРАММ ХАНГАМЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

ББСБ-ын үйл ажиллагаанд ашиглах техник, тоног төхөөрөмжийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

№	Техник, тоног төхөөрөмжийн төрөл	Техникийн үзүүлэлт	Худалдан авсан, түрээслэсэн алин болох	Тоо ширхэг

ББСБ нь дээрх тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, компьютерээс гадна нягтлан бодох бүртгэлийн
(программ, түүнийг зохиосон байгууллагын нэр) программ, зээлийн мэдээллийн санд мэдээ өгч, авах зориулалт бүхий (программ, түүнийг зохиосон байгууллагын нэр) программ, болон
. –Г. (худалдан авсан, худалдан авах гэж байгаа эсхүл гэрээ хийсэн байгаа аль нь эсэхийг бичих) бөгөөд өдөр тутмын мэдээ, мэдээлэл боловсруулалтын ажилд компьютерийн
. (программ, түүнийг зохиосон байгууллагын нэр) программ ашиглах болно.

ББСБ нь үйл ажиллагаа явуулах байрыг:

худалдан авсан
түрээсэлсэн

бөгөөд энэхүү байр нь ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэхэд тохиромжтой, аюулгүй байдлын хувьд бүрэн хамгаалагдсан болно.

Худалдан авсан байрны үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээ
Түрээслэсэн байрны түрээсийн гэрээ
Харуул хамгаалалтын асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн
талаар тайлбар

“ ” ББСБ-ыг төлөөлж

.
/албан тушаал/

/ /
/гарын үсэг/

/.. /
/овог, нэр/

"Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам"-ын 5 дугаар хавсралт

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨМЖ

1. Бизнес төлөвлөгөө гэдэг нь ББСБ-ын стратеги, зорилтыг тодорхойлж, банк бус санхүүгийн үйл ажиллагааг эрхлэхэд түүний бүтэц, зохион байгуулалт, үйлчилгээний шуурхай, найдвартай ажиллагаа, удирдлагын ур чадвар, санхүү, төлбөрийн чадварын үзүүлэлт, үр ашгийг жил тутам сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой цаг хугацаагаар төлөвлөн боловсруулсан баримтыг хэлнэ.

2. ББСБ нь бизнес төлөвлөгөөг өөрийн үйл ажиллагааны онцлогтой уялдуулан боловсруулах бөгөөд дараах асуудлуудыг заавал тусгасан байна. Үүнд:

- 2.1. банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зорилго, баримтлах бодлого, ББСБ-ын хэтийн төлөв байдал;
- 2.2. банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд ашигтай байх макро болон микро түвшин дэх боломжит нөхцлүүд;
- 2.3. ББСБ-ын тайлан тэнцэл, мөнгөн хөрөнгийн урсгал, орлого, зарлагын 3-5 жилийн төсөөлөл;
- 2.4. актив, пассивын бүтэц, хэмжээ түүний удирдлагыг сайжруулах төлөвлөгөө, хүү, шимтгэлийн ерөнхий нөхцлүүд, энэ талаар баримтлах бодлого;
- 2.5. үйл ажиллагаатай холбогдон гарах эрсдэлийг тодорхойлж, түүнийг удирдахад авах арга хэмжээ.

3. Бизнес төлөвлөгөөг банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэн явуулж эхэлснээс хойш 3-5 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөн боловсруулна.

4. Бизнес төлөвлөгөө нь дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:

1/. НҮҮР ХУУДАС:

Бизнес төлөвлөгөөний нүүр хуудсанд дараах зүйлсийг тусган харуулна:

- ББСБ-ын нэр, хаяг;
- Бизнес төлөвлөгөөний нэр;
- Хувилбарын дугаар;
- Боловсруулсан огноо;
- Зохиогчийн нэр, хаяг;
- Зохиогчийн тэмдэглэл;
- ББСБ-ын удирдлагын нэр, хаяг.

2/. ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ

Энэ бүлэгт тухайн бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэгч ББСБ-ын тухай, хэрэгжүүлэх гэж буй бизнес төлөвлөгөөний эрхэм зорилго, зорилт, амжилтын үндэс, учирч болох эрсдэл болон санхүүгийн бусад үзүүлэлтүүдийн тухай товч мэдээллийг багтаана.

Эрхэм зорилго гэдэг нь хэний ямар хэрэгцээг, яаж хангах тухай тодорхойлолт юм.

Зорилт гэдэг нь эрхэм зорилтонд хүрэхийн тулд шат дараалан хэрэгжүүлэх, хугацаатай, хэмжигдэхүйц бодитой үр дүн буюу хүрэх цэг юм.

3/. БИЗНЕСИЙН ТАНИЛЦУУЛГА

Бизнесийн танилцуулга гэдэг нь тухайн ББСБ-ын нэр, хаяг, өсөж хөгжиж ирсэн түүх, хариуцлагын тогтолцоо, зах зээлийн нөхцөл, төлөв байдал, эрхэлж байгаа үйл ажиллагаа, гаргаж буй үйлчилгээ, түүнчлэн удирдлага боловсон хүчний хангалт, санхүүгийн чадавхи ба байдал бизнес төлөвлөвлөгөө бичих болсон шалтгаан, зорилго зорилтууд түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр, зээлийг эргэж төлөх хугацаа, үр ашиг, борлуулалтын орлого, ашиг зэргийг тусган харуулсан хураангуй тодорхойлолт юм.

Бизнесийн танилцуулга нь дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ:

- Бизнес ба түүний түүх;
- Зах зээлийн нөхцөл төлөв байдал;
- Одоо явуулж байгаа үйл ажиллагаа;
- Удирдлага боловсон, хүчин;
- Санхүүгийн байдал төлөв;
- Бизнес төлөвлөгөө бичих болсон шалтгаан, зорилго.

4/. МАРКЕТИНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бизнес төлөвлөгөөний “маркетингийн төлөвлөгөө”-г дараах гурван хэсэг дээр бичнэ үү.

4.1.Зах зээлийн шинжилгээ:

Маркетингийн төлөвлөгөөг боловсруулахын тулд юуны түрүүнд зах зээл буюу хэрэглэгчдийнхээ тухай судалж мэдэх, зах зээлийг тань булаацалдах өрсөлдөгчид, танайд бараа үйлчилгээ үзүүлэх түншүүд, зуучлагчдынхаа талаар судлах ёстой.

4.2.Маркетингийн стратеги:

Маркетингийн стратеги гэдэг нь зах зээл рүү хандсан төлөвлөгөө буюу амжилт олохын тулд танай байгууллагын хэрэглэж буй арга замууд юм.

4.3.Маркетингийн иж бүрдэл:

Танай байгууллага зах зээл рүүгээ хандах арга зам буюу стратегиа тодорхойлсон бол одоо зах зээл дээр таатай байдал үүсгэхийн тулд байгууллагын ашигладаг хүчин зүйлс буюу маркетингийн иж бүрдлийг хэрхэн бүрдүүлэх вэ? Маркетингийн иж бүрдэлд үйлчилгээ, үнэ, идэвхижүүлэлт, хуваарилалтын талаар тусгана.

5/. МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бизнес төлөвлөгөөний энэ бүлэгт удирдлага, зохион байгуулалт, боловсон хүчний хэрэгцээ гэсэн асуудлуудыг багтааж оруулна.

5.1.Удирдах баг:

Бизнес төлөвлөгөөний энэ хэсэгт удирдах багийн гишүүд нь банк санхүү, менежментийн чиглэлээр хэр мэргэшсэн, бие биенээ орлох чадвар нь ямархуу болох, мэргэжил дадлага туршлагатай байх шаардлагыг хэр зэрэг хангасан байдал болон эрх мэдэл, ажил үүргийг оновчтой хуваарилсан байдал зэргийг харуулах хэрэгтэй.Удирдах багийн болон мэргэжилтэн (хуулийн зөвлөх г.м.), тэргүүлэх ажилтны (салбаруудын удирдлага г.м.) дадлага, туршлага, тухайн салбарт ажилласан байдал, үүрэг хариуцлага зэрэг тухайн ажил үүргийг гүйцэтгэхэд шаардагдах мэдээлэл бүхий намтрыг бизнес төлөвлөгөөндөө хавсаргах шаардлагатай.Түүнчлэн удирдах багийн гишүүн бүрийн эрх үүрэг хариуцлагыг нягт тогтоож, хэн нь хэнд захирагддаг, хэн эцсийн шийдвэр гаргадгийг зааж байгууллагын дүрэмд оруулан баталгаажуулж, төлөвлөгөөндөө хавсаргаж болно.

5.2.Зохион байгуулалтын бүтэц:

Удирдах багийн дор зохион байгуулалтын шат дамжлага багатай, хамгийн үр ашигтай бүтцийг тогтоох нь чухал.Цөөн хүнтэй хамт олны зохион байгуулалтын бүтцийн үр ашигтай байх үндэс зарчим нь нэг удирдлагатай байх, ажил үүргийг оновчтой хуваарилах, удирдагч мэдээллээр сайн хангагддаг байх, ажиллагсад ажлынхаа үр дүнг сонирхдог байх, хяналт ил тод байх явдал болно.Энэхүү зарчмыг баримтлан зохион байгуулалтын бүтцээ тогтоож, бизнес төлөвлөгөөндөө оруулна.

Боловсон хүчин:

Энэ хэсэгт шаардлагатай мэргэжлийн боловсон хүчин тэдгээрийн тоо түүнчлэн мэргэжил эзэмшүүлэх эсвэл мэргэжил дээшлүүлэх сургалтынасуудлуудыг төлөвлөх болно.

Энэ хэсэгт нийт ажиллагсад болон шаардлагатай мэргэжлийн боловсон хүчний хэрэгцээ, уг ажлыг гүйцэтгэх ажиллагсдын тоо түүнчлэн нийт ажиллагсдын сар, жилийн цалингийн хэмжээ, цалингийн шимтгэлийг тооцоолж төлөвлөнө.

Сургалтанд зориулсан зардал хэдийгээр гаднаас нь харахад ашиггүй мэт боловч үр ашгаа зүй ёсоор өгдөг гэдгийг анхаарвал зохистой.

6/. САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Санхүүгийн төлөвлөгөөнд дараах хэсгүүд орно. Үүнд :

- Нийт орлогын тооцоо;
- Үйл ажиллагааны урсгал зардлын тооцоо;
- Ашиг/ алдагдлын тооцоо;
- Алдагдалгүй ажиллагааны тооцоо;
- Мөнгөн урсгалын тооцоо.

7/. ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ

6.1. Эрсдэлийн төрлүүд:

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд 4 төрлийн үндсэн эрсдэлийг тооцоолоход болно. Үүнд:

- Техник, тоног төхөөрөмжийн
- Санхүүгийн буюу зээлийн
- Хүний хүчин зүйлийн
- Хууль зүйн

6.2. Эрсдэлийг багасгах боломжууд:

Эдгээр дурдсан эрсдэлээс чухам ямар нь танай бизнест тохиолдож болох магадлал илүү вэ? Түүнийг доод хэмжээнд байлгахын тулд та ямар арга хэмжээ төлөвлөснөө бичих нь зүйтэй. Дараа нь даатгалд хамруулж болох эрсдэлийг ангилж, ямар нөхцлөөр аль даатгалын компанитай гэрээ хийхээ тодорхойлж бич. Харин даатгалд үл хамаарах эрсдэлийн талаар авах арга хэмжээг хэрхэн төлөвлөж байгааг тодорхойлох шаардлагатай.

Эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсны дүнд ББСБ-ын ашигт ажиллагаа хэрхэн хадгалагдаж үлдэхийг төлөвлөсөн үр дүнтэй жишиж харьцуулаарай.

"Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам"-ын 6 дугаар хавсралт

*/Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 28 дугаар тогтоолоор нэмсэн/
/Энэ хавсралтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 532 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/*

ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ МЭДЭЭ
/долоо хоногоор/

.....сарын.....өдрөөссарынөдрийн валютын арилжааны мэдээ
/ББСБ-ын нэр/

Д/д	Өдөр	Иргэд, хуулийн этгээдийн аль нь болох	Валют /тус бүрээр/	Ханш	Дүн		Зориулалт
					авсан	зарсан	

Мэдээ гаргасан ажилтны албан тушаал

Овог нэр

Гарын үсэг.....

/тамга/

"Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын
журам"-ын 7 дугаар хавсралт

/Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 28 дугаар тогтоолоор нэмсэн/

ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ МЭДЭЭ
/сараар/

20... оны ...-р сарын ... өдөр

ББСБ-ын нэр:					Утас:	Факс:
№	Худалдаж авсан	Валютын төрөл /тус бүрээр/	Ханш	Валютын дүн	Америк долларт хөрвүүлснээр	Төгрөгөөр
1	Хуулийн этгээдээс					
2	Иргэдээс					
ДҮН						
Дундаж ханш						
№	Худалдсан	Валютын төрөл /тус бүрээр/	Ханш	Валютын дүн	Америк долларт хөрвүүлснээр	Төгрөгөөр
1	Хуулийн этгээдэд					
2	Иргэнд					
ДҮН						
Дундаж ханш						

Мэдээ гаргасан ажилтны албан тушаал

Овог нэр

Гарын үсэг.....

/тамга/

/Энэ хавсралтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 532 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/

Санхүүгийн зохицуулах хорооны
2008 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн
186 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



МОНГОЛ УЛС

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ГЭРЧИЛГЭЭ**

Дугаар . . .

. . . оны . . . сарын . . . өдөр

Монгол улсын “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”, “Аж ахуйнүйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”, бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны _____ оны _____ сарын _____ өдрийн _____ дугаар _____ тогтоолоор _____-д

үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА

"Тэмдэг"

*Энэхүү гэрчилгээ нь
хавсралтын хамт
хүчинтэй.*



МОНГОЛ УЛС

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

_____ **ТООТ**

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ**

"Тэмдэг"

Банк бус санхүүгийн байгууллагад зориулсан тэмдэглэлүүд

ДӨРӨВ. Хуулийн этгээдийн нэгжийн тэмдэглэл:

Д/д	Нэгжийн нэр, дугаар	Нэгжийн хаяг, хаягийн өөрчлөлт	Нэгжид зөвшөөрөл олгосон огноо	Нэгжид зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар	Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар

ТАВ. Дүрмийн сангийн өөрчлөлтийн тэмдэглэл:

Д/д	Дүрмийн сангийн нэмэгдүүлсэн, хорогдуулсан хэмжээ	Зөвшөөрөл олгосон огноо	Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар	Дүрмийн сангийн хэмжээ

Санхүүгийн зохицуулах хорооны
2008 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн
186 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт



МОНГОЛ УЛС

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭГЖИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар . . .

. . . оны . . . сарын . . . өдөр

Монгол улсын “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”, бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны даргын _____ оны ____ сарын ____ өдрийн ____ дугаар тушаалыг үндэслэн _____ хот/аймаг дахь

_____ тоот регистрийн дугаар бүхий _____ тоот улсын бүртгэлийн
гэрчилгээтэй _____ оноосон нэр бүхий
ББСБ-д _____ хот/аймаг - ийн
_____ дүүрэг/сум - нд

(нэгжийн нэр, дугаар)

байгуулахыг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА

"Тэмдэг"